

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2018.02.19-02.23

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

Үндэсний статистикийн хороо ДНБ-ний 2017 оны урьдчилсан гүйцэтгэлийг гаргалаа. Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ 2017 оны урьдчилсан гүйцэтгэлээр оны үнээр 27,167.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх онтой харьцуулахад 13.5 хувиар нэмэгдсэн бол 2010 оны зэрэгцүүлэх үнээр 5.1 хувиар өсөж, 16,873.8 тэрбум төгрөгт хүрчээ.

ДНБ-ний 5.1 хувийн өсөлтийн салбаруудын оролцоог авч үзвэл боловсруулах салбар 1.3 пункт, бөөний, жижиглэн худалдааны салбар 1.0 пункт, тээвэр, мэдээлэл, холбооны салбар 1.3 пункт, үйлчилгээний бусад салбар 1.2 пункт, бүтээгдэхүүний цэвэр татвар 1.5 пунктээс бүрдэж байна. 2016 онтой харьцуулахад нүүрсний салбарын үйл ажиллагаа нэмэгдсэнтэй холбоотойгоор бусад салбаруудад өсөлт гарсан байна. Тухайлбал, нүүрсний тээвэрлэлт болон тээвэрлэлт нэмэгдснээс шатахууны худалдаа өсжээ. Түүнчлэн боловсруулах салбар болон бүтээгдэхүүний татварт өсөлт гарсан байна.

ДНБ-ний эцсийн ашиглалтын аргаарх бүтцэд өрхийн хэрэглээ 49.2%, Төрийн байгууллагын хэрэглээ 12.3%, Хөрөнгийн нийт хуримтлал 36.2%, Цэвэр экспорт 2.3%-ийг тус тус эзэлж байна.

Монголбанкны мэдээгээр 2017 оны 12 сарын байдлаар Монгол улсын урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 907.1 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн дансны тэнцэл 2,439.0 сая ам долларын ашигтай гарснаар нийт төлбөрийн тэнцэл 811.9 сая ам.долларын ашигтай гарчээ.

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2018 оны 1 дүгээр сард 15.8 их наяд төгрөг болж, өмнөх сараас 96.7 (0.6%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 3.8 (31.7%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны 1 дүгээр сард 13.7 их наяд төгрөг болж, өмнөх сараас 41.6 (0.3%) тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 1.3 (10.3%) их наяд төгрөгөөр өсөв.

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2018 оны 1 дүгээр сард 530.4 тэрбум төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 416.2 тэрбум төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 114.2 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Нэгж	Хэмжээ
ДНБ	2017	тэрбум төг	27,167.0
ДНБ өсөлт	2017	%	5.1
Инфляцийн түвшин	2018.I	%	6.9
Монголбанкны бодлогын хүү	2018.I	%	11.0
Гадаад худалдааны тэнцэл	2018.I	сая USD	62.7
Гадаад худалдааны эргэлт	2018.I	сая USD	784.98

Валютын ханш /төг/

Валют	2018.I дундаж	2018.02.23
USD	2,425.77	2,397.69
CNY	377.34	378.25
EUR	2,956.10	2,947.96
RUB	42.80	42.40
KRW	2.27	2.22
JPY	21.85	22.42

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт
MSE TOP 20	Монгол	20,247.4
Dow Jones	АНУ	25,309.9
S&P 500	АНУ	2,447.3
Nasdaq	АНУ	7,337.3
S&P/TSX	БНХАУ	15,638.4
FTSE 100	Англи	7,244.4
S&P/ASX 200	Австрали	6,029.5
Nikkei 225	Япон	22,072.1
Hang Seng	Хонг Конг	31,267.1

Бондын өгөөж

Үзүүлэлт	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.7%	113.53
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.6%	99.45
Mongol 2022 (Чингис)	USD	5.1%	98.42
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.8%	116.73
Mongol CNY (Димсам)	CNY	7.5%	100.56
DBM' 23 (Самурай)	JPY	1.5%	104.90
TDBM' 2020	USD	9.3%	108.90

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	ҮөҮ
Libor 1M	1.63	0.65 ▲
Libor 3M	1.956	0.65 ▲
Libor 6M	2.181	0.64 ▲
Libor 1YR	2.459	0.41 ▲
US 6M Bond	1.836	-0.42 ▼
US 2YR Bond	2.229	-0.36 ▼
US 3YR Bond	2.378	-0.35 ▼
US 5YR Bond	2.603	-0.58 ▼
US 10YR Bond	2.855	-0.38 ▼
ISDA USD 1YR	2.275	-0.04 ▼
ISDA USD 2YR	2.482	-1.35 ▼
ISDA USD 3YR	2.609	-1.66 ▼
ISDA USD 5YR	2.728	-1.73 ▼

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хаалт /USD/	Өөрчлөлт
Метал		
Алт /spot/	1,328.9	-3.03 -0.23% ▼
Мөнгө /spot/	16.5	-0.08 -0.46% ▼
Зэс	23.3	-2.85 -0.87% ▼
Цагаан алт	996.7	-0.62 -0.06% ▼
Эрчим хүч		
Нүүрс	64.3	0.00 0.00%
WTI газрын тос	63.5	+0.78 +1.24% ▲
Brent газрын тос	67.3	+0.92 +1.39% ▲
Дизель түлш	592.2	+5.50 +0.94% ▲
Байгалийн хий	2.6	-0.01 -0.34% ▼
Хөдөө аж ахуй		
Амьд бод мал, 1 паунд	124.8	-0.52 -0.42% ▼

Эх сурвалж: Монгол улсын Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg.com

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Өнгөрсөн 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 57 компанийн 243 сая төгрөгөөр 554,495 ширхэг хувьцаа арилжигдав.

“Хөвсгөл Хүнс” /HHS/ компанийн хувьцаа 32.23%-иар буюу хамгийн ихээр өсч 1,034 төгрөгт хүрч хаагдсан бол “Сүү” /SUU/ компанийн хувьцаа 16.15%-иар буурч 204.06 төгрөгт хүрч хаагдлаа.


Мөн 2-р сарын 19-с 2-р сарын 23-ны хооронд ЗГҮЦ-ын анхдагч зах зээлд арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн нийт 5 удаагийн хэлцлээр 3,321 ширхэг үнэт цаас 333,310,450 төгрөгөөр арилжаалагдлаа.

Харин компанийн бондын хувьд хоёрдогч зах зээл дээр энэ долоо 47 ширхэг бондыг 2,095,200 төгрөгөөр арилжаалсан байна.

2-р сарын 23-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,455.6 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 20247.41 нэгж болж өмнөх 7 хоногоос 6.45%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

Арилжааны бүтэц



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /төг/
Арилжигдсан үнийн дүн	581,234,317
Зах зээлийн үнэлгээ	2,455,629,147,724

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20*	20,247.41	-6.45% ▼
MSE I индекс	10,150.15	-4.91% ▼
MSE II индекс	9763.50	-3.49% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
АПУ	129,264	89,285,926
Айтүүлс	89,378	11,807,211
Сүү	74,423	15,537,922
Тавант Толгой	4,674	49,677,780
Говь	1,329	31,033,560

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Хөвсгөл Хүнс	1,034.00	32.23% ▲
Хүннү Менежмент	61.69	32.21% ▲
Тушиг уул	422.00	31.95% ▲
Стандарт ноос	523.00	30.75% ▲
Эрдэнэт авто зам	920.00	24.32% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Сүү	204.06	-16.15% ▼
Э-транс ложистикс	85.00	-15.00% ▼
МИК холдинг	10,010.00	-12.19% ▼
Булган гурил тэжээл	1,500.00	-11.76% ▼
Айтүүлс	134.09	-9.68% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Новелинвестмент	188,508,227
МирЭссетСекьюритис	138,645,056
БиДиСек	124,748,484
ГоломтКапитал	98,427,186
Стандартинвестмент	85,135,905

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
Апу	673.38	716,598
Таван толгой	10,990	578,790
МИК	10,010	207,300
Говь	22,840	178,177
Сүү	204.06	70,196

*MSE TOP-20 индексийн багц шинэчлэгдсэн: дэлгэрэнгүйг ЭНЭ 7 ХОНОГИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД хэсгээс үзнэ үү

7 ХОНОГИЙН ЗГҮЦ БОЛОН КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

ЗГҮЦ-ны анхдагч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Үнэ	7 хоног	Хүү %
-	-	-	-	-	-	-

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Үнэ	7 хоног	Хүү %
1	Z GEB-BL-01/05/18-A0340-0	107	10,475,300	97,900	28	11.790%
2	Z GEB-BD-25/04/20-A0236-16.933	450	49,050,000	109,000	156	16.993%
3	Z GEB-BL-20/03/18-A0221-0	1,997	197,563,210	98,930	52	17.613%
4	Z GEB-BD-26/09/19-A0326-13.955	75	7,492,500	99,900	104	13.955%
5	Z GEB-BL-20/03/18-A0221-0	692	68,729,440	99,320	52	17.613%

Компанийн бондын арилжаа / хоёрдогч зах зээл /

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Үнэ	7 хоног	Хүү %
1	SUU-BD-29/06/18-C0006-17.5	47	2,095,200	104,760	104	14.820%

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	Нийт ногдол ашиг /сая төг/	Нэгж хувьцаанд ногдох ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	APU	АПУ ХК	10,641.8	10.0	2018.02.19	N/A	2018.06.01-ний дотор
2	BTG	Баянтээг ХК	25.3	100.0	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор
3	MIE	Материалимпекс ХК	13.7	10.0	2018.02.19	2018.03.26	2018.12.31-ний дотор
4	MNP	Монгол шуудан ХК	273.5	2.7	2018.02.13	N/A	2018.05.01-нээс
5	MMX	Махимпекс ХК	380.1	100.0	2018.02.13	2018.04.05	2018.10.01-нээс
6	TCK	Талх чихэр ХК	174.0	170.0	2018.02.12	2018.04.06	2018.07.01-нээс
7	ADL	Адуун чулуун ХК	409.7	130.0	2018.02.07	2018.03.01	тодорхойгүй
8	TAN	Тахь-ко ХК	128.1	108.0	2018.02.05	N/A	2018.05.01-ний дотор
9	UBH	Улаанбаатар хивс ХК	40.5	100.0	2018.02.05	2018.02.26	2018.05.01-нээс
10	GOV	Говь ХК	1,716.2	220.0	2018.02.02	N/A	2018.04.24-нөөс
11	HRM	Гермес центр ХК	392.7	5.0	2018.01.24	2018.02.15	2018.03.06-наас

КОМПАНИЙН МЭДЭЭ

2017 ОНД КОМПАНИУД ХЭР ХЭМЖЭЭНИЙ АШИГТАЙ АЖИЛЛАСАН БЭ?

“Мах импекс” компаний 2017 оны борлуулалтын орлого 37.5 хувиар өсжээ

“Мах импекс” компаний 2017 оны борлуулалтын орлого 2016 оны үзүүлэлтээс 37.5%-аар өсөж 10.3 тэрбум төгрөгт хүрсэн бол нийт цэвэр ашиг 69.9 хувиар буурч 354.8 сая төгрөг болжээ. Ашгийн хэмжээ буурахад үйл ажиллагааны зардлын хэмжээ өссөн нь гол нөлөөг үзүүлсэн байна. “Мах импекс” компани 2017 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 100 төгрөг буюу нийт 380.1 сая төгрөгийн ноогдол ашиг хуваарилахаар болсон ба тус компани таван жилийн турш дээрх хэмжээний ноогдол ашгийг олгож байгаа юм.

Монголын Хөрөнгийн биржийн сүүлийн арилжаагаар “Мах импекс” компанийн хувьцааны ханш өсөж 2,800 төгрөг болсон байна.

“Дархан нэхий” ХК-ийн борлуулалтын орлого 2017 онд 38 хувиар өсжээ

“Дархан нэхий” ХК-ийн борлуулалтын орлого 2017 онд 38 хувиар өсөж, 19.1 тэрбум төгрөг боллоо. Компани 2017 онд үйлдвэрлэлээ нэмэгдүүлсэн боловч зах зээлийн нөхцөл байдлыг харгалзан үнээ бууруулсан учраас ашиг нь буурсан гэдгийг Гүйцэтгэх захирал Э.Батсайхан онцолсон. 2017 оны эцэс гэхэд компанийн цэвэр ашиг өмнөх онохоос 42 хувиар буурч, 1.08 тэрбум төгрөг болсон байна. Компанийн санхүүгийн тайланг харвал 2017 онд ерөнхий ба удирдлагын зардал хоёр дахин өсөж, 1.29 тэрбум төгрөг болсон нь онцлох өөрчлөлт байлаа. 2017 онд тус компанийн борлуулалтын орлогод эзлэх экспортын хувь 50-60 хувиас 30% болж буурчээ. 2018 онд экспортын зах зээлээ тэлж Европын орнууд мөн БНХАУ, ОХУ руу экспорт хийхээр зорьж байна. МХБ-д “Дархан нэхий” ХК-ийн хувьцааны ханш өнгөрсөн нэг жилийн хугацаанд 10 гаруй хувиар өссөн. 2-р сарын 23-ны байдлаар нэгж хувьцаа нь 21,500 төгрөгөөр арилжигдаж байна.



“Айтүүлс” ХК-ийн цэвэр ашиг 3.4 дахин өсжээ

Өнгөрсөн оны 11 дүгээр сард IPO гаргасан “Айтүүлс” компанийн цэвэр ашиг 2017 онд 3.4 дахин өсөж, 62.9 сая төгрөгт хүрлээ. Мөн борлуулалтын орлого нь жилийн дүнгээр 2.8 дахин өссөнөөр 1.3 тэрбум төгрөгт болсон байна. Үүнд үндсэн бус үйл ажиллагааны орлого дийлэнх хувийг бүрдүүлсэн талаар тус компани мэдээллээ. “Айтүүлс” ХК 2017 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар компанийн ТУЗ шийдвэрлэлээ. “Айтүүлс” компани 2011 оноос эхлэн мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд цаашид Дархан хотод модуляр дата төвийн парк барьж цахим мэдээллийн байршуулалт, дамжуулалт, хадгалалтын үйлчилгээг үзүүлэхээр зорьж байгаа юм. Одоогоор дата төвийн барилгын ажил 40 хувьтай байгааг “Айтүүлс” ХК-ийн Гүйцэтгэх захирал И.Алтантулга мэдээллээ байна. Түүнчлэн хувьцааных нь ханш IPO гаргасны дараа хоёр долоо хоногийн хугацаанд 2.5 дахин өсөж, 254 төгрөгт хүрч байжээ. Харин өнөөдрийн байдлаар 134,09 төгрөг болсон байна.

“Барилга корпораци” ХК-ийн борлуулалтын орлого 10 тэрбум 33 сая төгрөг болов

МХБ-ийн биржийн III ангилалд бүртгэлтэй “Барилга корпораци” ХК 2017 оны санхүүгийн тайлангаа танилцууллаа. Тус компанийн борлуулалтын орлого өнгөрсөн онд 10 тэрбум 33 сая төгрөг болсон нь 2016 оны эцэсээс 25 орчим хувиар өссөн үзүүлэлт болсон байна. Борлуулалтын орлого ийнхүү нэмэгдэхэд МУИС-ийн шинэ номын сангийн барилгыг барьсан болон “Оюу Толгой”-ийн туслан гүйцэтгэгчээр эргэн ажиллаж эхэлсэн нь голчлон нөлөөлсөн гэдгийг тус компанийн зүгээс мэдэгдлээ. Үүнээс гадна “Барилга корпораци” ХК 2017 оны эцсийн байдлаар гадаад валютын ханшийн зөрүүнээс 18 сая орчим төгрөгийн алдагдал хүлээсэн байна. Хэдий тийм боловч тус компанийн нийт ашиг 2016 онтой харьцуулахад 2.8 дахин нэмэгдсэнээр цэвэр ашиг нь 397 сая 202 мянган төгрөг болж өсжээ. Ийнхүү “Барилга корпораци” ХК 2016 онд 103 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж байсантай харьцуулахад компанийн үйл ажиллагаа эрс сэргэсэн гэдгийг онцолсон юм.



“Монголын цахилгаан холбоо” ХК: 2017 онд зургаан сая төгрөгийн ашигтай ажилласан

МЦХ ХК 2017 онд зургаан сая төгрөгийн ашигтай ажиллалаа. Санхүүгийн үзүүлэлтүүдийг харвал жилийн турш 17.8 тэрбум төгрөгийн өртөгтэй 20.7 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна. Ингэснээр борлуулалтын ашиг болох 2.9 тэрбум төгрөг, хүүгийн орлогоос нэг тэрбум төгрөг олсон байна. Үүнээс бусад зардал болох 3.7 тэрбум төгрөгийг хассанаар компанийн цэвэр ашиг зургаан сая төгрөгт хүрчээ. Өөрөөр хэлбэл ашгийн хэмжээ нь өмнөх оноос долоо дахин буурсан байна. 2015 онд тус компани 730 орчим сая төгрөгийн алдагдалтай ажиллаж байжээ. МЦХ компани хувьчлагдсан 21 жилийн хугацаандаа 18 тэрбум төгрөгийн ногдол ашиг тарааж, Засгийн газарт 10 гаруй тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилж байсан юм. Тус компанийн хувьцааны ханш өнөөдрийн байдлаар 510.06 төгрөг байв.

“Багануур” ХК-ийн борлуулалтын орлого 10 хувиар өсөж, 125 тэрбум төгрөгт хүрэв

“Багануур” компанийн борлуулалтын орлого өнгөрсөн онд 10%-иар өсөж, 125 тэрбум төгрөгийг давсан байна. Харин тайлант үеийн цэвэр ашиг 1.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос бага зэрэг буурчээ. Тус компанийн мэдээлснээр 2017 онд дөрвөн сая гаруй тонн нүүрс олборлон борлуулсан байна. Харин 2018 онд 19.1 сая метр куб хөрс хуулж, 4.1 сая тонн нүүрс олборлон борлуулахаар төлөвлөжээ. Эрчим хүчний хэрэглээ өсөж байгаатай холбоотойгоор хүчин чадлаа нэмэгдүүлэх шаардлага тулгарч байгааг тус компани онцолж байна.

Түүнчлэн цаашид үйл ажиллагаагаа тогтвортой үргэлжлүүлэхэд дэмжлэг шаардлагатай байгааг “Багануур” компанийн Гүйцэтгэх захирал хэлж байсан юм. Үүнээс гадна “Багануур”-ын уурхайн хүчин чадлыг 2019 онд 4.9 сая тонн, 2020 онд 6.7 сая тоннд хүргэх шаардлага гарч байгаа аж. Үүнээс үүдэн 2018-2022 онд 353 тэрбум төгрөгийн өртөг бүхий тоног, төхөөрөмж худалдан авч шинэчлэл хийх шаардлагатай байна гэж тус компанийн зүгээс мэдээллээ. Учир нь Багануур дүүрэгт 700 мВт-ын цахилгаан станцыг хоёр үе шаттайгаар 2020, 2024 онд барьж ашиглалтад оруулах, Дулааны III цахилгаан станц болон Дулааны II цахилгаан станцад өргөтгөл хийх төлөвлөгөөг танилцуулаад байгаа юм.

Сүүлд тус компанийн хувьцаа 1901.00 төгрөг буюу нэгдүгээр сарын түвшнээс 400 төгрөгөөр доогуур арилжигдаж байна.

Эх сурвалж: BloombergTV.mn

“Талх чихэр” ХК-ийн борлуулалтын орлого 2017 онд 12%-иар өсжээ

МХБ-д бүртгэлтэй “Талх чихэр” ХК-ийн борлуулалтын орлого 2017 онд 12 хувиар өсөж, 36.4 тэрбум төгрөг боллоо. Тус компанийн ерөнхий ба удирдлагын зардал 2016 оныхтой харьцуулахад өөрчлөлт багатай, нэг хувиар өсөж, 6.3 тэрбум төгрөг болсон байна. Харин үйл ажиллагааны бус зардал нь 2.3 дахин нэмэгдэж, 796.6 сая төгрөг болсон талаар санхүүгийн тайландаа дурджээ. Харин цэвэр ашиг 13.8 хувиар буурч, 1.1 орчим тэрбум төгрөг болсон байна. Цэвэр ашгийнхаа 15.4 хувийг ногдол ашигт олгохоор “Талх чихэр” компани шийдвэрлэжээ. Ингэхдээ нэгж хувьцаанд 170 төгрөгийн ногдол ашиг хуваарилах бөгөөд ирэх долоодугаар сарын нэгнээс компани дээрээ олгохоор болсон байна. “Талх чихэр” ХК борлуулалтын 3000 гаруй цэгтэй, нийт 20 гаруй нэр төрлийн талх, 30 гаруй нэр төрлийн нарийн боов, 20 гаруй төрлийн бялуу зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа аж. Тус компанийн хувьцааны ханш Монголын Хөрөнгийн биржид сүүлийн нэг жилийн дотор 30 орчим хувиар өсөж, сүүлд 26,500 төгрөг болсон байна.

МҮЦБ: “АНД ЭНЕРГИ” ХК IPO ГАРГАСНААС ХОЙШ 103 СЯА ТӨГРӨГИЙН ГҮЙЛГЭЭ ХИЙГДСЭН

Лед гэрэл үйлдвэрлэгч “Анд Энерги” ХК 2017 оны 11 дүгээр сард IPO гаргаснаас хойш 71 удаагийн арилжаагаар 103 сая төгрөгийн гүйлгээ хийгдээд байгааг Монголын Үнэт Цаасны Бирж мэдээллээ. Гурван сар гаруйн хугацаанд хувьцааны ханш нь 26.7 хувиар унаад байгаа юм. Ингэснээр хамгийн сүүлийн байдлаар нэгж хувьцаа нь 44 төгрөг боллоо. Тус компани нийт татан төвлөрүүлсэн 1.6 тэрбум төгрөгийн 50 орчим хувийг үйлдвэрийн барилга байгууламжид, 17 хувийг тоног төхөөрөмжид, 15 хувийг механик цех барих зардалд тусгахаар тооцоолжээ. Барилгын ажлыг энэ оны гурав, дөрөвдүгээр сарын үед эхлүүлж, III улиралд ашиглалтад оруулах зорилт тавин ажиллаж байгаагаа тус компани мэдээлсэн юм.

“Анд Энерги” компани 2014 оны есдүгээр сараас “Эрдэнэт LED” гэрлийн үйлдвэрийг ашиглалтад оруулж үйл ажиллагаагаа явуулж байна. Одоогоор 35 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Тус компанийн Гүйцэтгэх захирал хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын үеэр “Бүтээгдэхүүнээ I улиралд багтан Улаанбаатар хотод борлуулж эхлэх” талаар мэдэгдэж байсан юм.

Анд Энерги” компанийн ТУЗ-ын хурал энэ сарын 24-ны өдөр болох бөгөөд хурлаар 2017 оны жилийн эцсийн тайланг хэлэлцэж, ногдол ашиг хуваарилах эсэх, компанийн бүтэц, орон тоог шинэчлэн батлах талаар хэлэлцэхээ мэдэгдээд байгаа юм. Мөн цаашдын бизнес төлөвлөгөөг баталж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа товлох ажээ.



Эх сурвалж: BloombergTV.mn

ЭНЭ 7 ХОНОГИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

ТОП-20 ИНДЕКСИЙН БАГЦ ШИНЭЧЛЭГДЭЖ, БҮРТГЭЛИЙН I БОЛОН II АНГИЛЛЫН ИНДЕКСҮҮД ТООЦОГДОЖ ЭХЭЛЛЭЭ.

МХБ-ийн “Үнэт цаасны үнийн индекс тооцох тухай журам” шинэчлэгдсэнтэй холбогдуулан ТОП 20 индексийг бүрдүүлэх үнэт цааснуудыг өөрчилөөн ба тус индексийг тооцоолоход орсон гол өөрчлөлтүүд нь:

- Индексийн сагсыг жилд нэг удаа шинэчилдэг байх, улмаар ТОП-20 индексийг дагагч хөрөнгө оруулагчдын зардлыг бууруулах,
- Индексийн тооцоололд зөвхөн тухайн компанийн 5 ба түүнээс бага хувьтай тэнцэх хэмжээний үнэт цаас эзэмшигчдийн нийлбэр дүнг авч үзсэнээр индексийг олон нийтийн эзэмшлийн хувь /free-float/-д суурилан тооцоолох олон улсын жишигт нийцүүлэх,
- Тухайн үнэт цаасны индексэд үзүүлэх нөлөөг хязгаарлагч коэффициентыг улирлын давтамжтайгаар хянан, дахин тооцоолж байх зэрэг өөрчлөлтүүд болно.

2017 оны үзүүлэлтээр ТОП-20 индексийн сагсыг шинэчлэхэд өмнөх сагсанд багтаж байсан 18 компани хэвээр үлдэж, “Багануур”, “Женко тур бюро” ХК-иуд хасагдаж шинээр “Мик холдинг”, “Шивээ овоо” ХК-иуд нэмэгдэн шинэчилсэн сагсыг бүрдүүлж байна.

Түүнчлэн, Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны төслийн зөвлөмжийн дагуу бүртгэлийн шалгуураар ангилсан үнэт цаасны 2 индекс нэвтрүүлж байгаа болно. Энэ нь хөрөнгө оруулагч, арилжаанд оролцогчдод аль ангиллын компаниуд өсөлт, бууралттай байгааг харуулахаас гадна үнэт цаасны индексэд суурилсан бүтээгдэхүүн гаргах суурь нь болж байгаа юм. I ангиллын (MSE A Индекс) болон II ангиллын (MSE B Индекс) индексийг 2018 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс эхлүүлж, эхлэлийн утгыг 10,000 нэгж байхаар нөхөн тооцоолсон бөгөөд өнгөрсөн хугацаанд MSE A Индекс нь 7,9%-ийн өсөлттэй, харин MSE B Индекс нь 0,8%-ийн өсөлттэй байна.

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАХИАЛГЫН ХЭМЖЭЭ ЭХНИЙ ӨДӨР 900 СЯА ТӨГРӨГ ХҮРСЭВ

МХБ-д бүртгэлтэй “ЛэндМН ББСБ” ХК-ийн анхдагч зах зээлийн арилжааны захиалгын нээлт болон цан цохих ёслолын үйл ажиллагаа 2-р сарын 21-ны өдөр өндөрлөлөө.

“ЛэндМН ББСБ” ХК нь хиймэл оюун ухаанд суурилсан финтек / Fintech/ буюу цоо шинэ санхүүгийн бизнес моделийг Монголын улсын санхүүгийн салбарт 2016 онд анх удаа нэвтрүүлсэн компани бөгөөд өөрийн LendMN аппликейшнээр дамжуулан барьцаагүй, хямд өртөгтэй, хэрэглээний цахим зээлийн үйлчилгээг иргэдэд үзүүлдэг билээ. Тус компани нь Монголын банк бус санхүүгийн салбарыг төлөөлөн бүртгэгдэж буй анхны компани төдийгүй Монголын хөрөнгийн биржийн III дугаар ангилалд IPO хийж буй хамгийн анхны компани болж байгаагаараа онцлог юм. Ийнхүү “ЛэндМН ББСБ” ХК нь стартап буюу шинэлэг санаа бүхий, эрсдэл өндөртэй, бизнесийн өсөлтийн мөчлөгтөө яваа жижиг, дунд компаниуд хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгож олон нийтийн компани болох томоохон боломж нээлттэй байдгийг харуулж байна.

“Мирэ эссет секьюритис Монгол ҮЦК” ХХК андеррайтер компаниар ажиллаж байгаа бөгөөд үнэт цаасны захиалгыг 2-р сарын 21-нээс эхлэн 2018 оны 3 дугаар сарын 07-ны 13.00 цаг хүртэл авах бөгөөд эхний өдрөө захиалгын хэмжээ 900 сая төгрөг хүрсэн. Захиалгыг “Лэндмн” аппликейшн ашиглан өгөх боломжтой гэдгийг компани онцолж байгаа юм. Хувьцааны эрэлтийн хувьд, захиалгын хэмжээ нийлүүлэлтээс давбал хөрөнгө оруулагчдын тооноос хамаарч хувь тэнцүүлэн хуваарилахыг МХБ мэдэгдсэн. “Лэндмн ББСБ” нийт хувьцааныхаа 25 хувийг олон нийтэд санал болгож, таван тэрбум төгрөг татан төвлөрүүлснээр зээлийн эх үүсвэр буюу бизнесээ өргөжүүлэхэд ашиглах аж. Үүнээс 2.5 тэрбум төгрөгийг олон нийтээс, үлдсэн 2.5 тэрбум төгрөгийг тодорхойлсон стратегийн хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлэх юм байна. Өнөөдөр БНСУ-ын “Rhinos Asset Management” компани стратегийн хөрөнгө оруулалт хийж, нэг тэрбум төгрөг байршуулсныг “Мирэ Эссет Секьюритис Монгол” ҮЦК мэдэгдлээ.

Эх сурвалж: BloombergTV.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Эрдэс бүтээгдэхүүний экспорт 6.3 хувиар буурав

Эрдэс бүтээгдэхүүний экспорт нэгдүгээр сард 2017 оны мөн үетэй харьцуулахад 6.3 хувиар буурч, 351.7 сая ам.доллар боллоо. Үүнээс нүүрсний экспорт 39 хувийг бүрдүүлсэн байна. Гэхдээ нүүрсний экспорт мөнгөн дүнгээрээ 18.5 хувиар буурч, 135.8 сая ам.доллар болсон талаар Үндэсний статистикийн хорооноос мэдээллээ. Өнгөрсөн нэгдүгээр сард БНХАУ-ын талын тээвэрлэгч компаниудын эсэргүүцлээс болж Ганцмод боомтын авто замыг хаасан юм. Үүний улмаас Тавантолгойн бүлэг ордод олборлолт хийж байгаа "Эрдэнэс Тавантолгой", "Энержи Ресурс", орон нутгийн өмчит "Тавантолгой" компаниудын экспорт 10 хоног зогссон. Тиймээс цаашид боомтоор нэвтрүүлэх хүчин чадлыг сайжруулах, нэмэгдүүлэх талд хоёр орны Засгийн газрын түвшинд ярилцах шаардлагатай байгаа гэдгийг Уул уурхай, Хүнд үйлдвэрийн сайд мэдээлсэн юм. Нүүрс экспортлогч компаниудын хувьд 2018 онд үнэ ханш болон эрэлт тогтвортой байна гэж харж байгаа аж. Хэдий тийм боловч БНХАУ-ын Засгийн газар агаарын бохирдолтой тэмцэж байгаагийнхаа хүрээнд чанар муутай нүүрсний хэрэглээг хязгаарлаж байна. Үүнтэй уялдуулан Нарийнсухайтын бүлэг ордод үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд баяжуулах үйлдвэрүүдээ ашиглалтад оруулж, боловсруулсан нүүрс экспортлохоор зорьж байна гэдгийг "Өсөх зоос" ХХК-ийн захирал Ч.Чинбат онцоллоо.

Харин зэсийн баяжмалын экспорт найм орчим хувиар буурч, 126.8 сая ам.доллар болсон бол цайрын хүдрийн экспорт 61 хувиар өсөж, 19.4 сая ам.доллар болжээ. Харин үнэт чулуу, металл, гоёлын зүйлсийн экспорт 49.3 хувиар өссөн байна.

Уул уурхайн томоохон компаниудын чөлөөт мөнгөн урсгал нэмэгджээ

Голлох металлуудын ханш олон жилийн дээд түвшинд хүрсний нөлөөгөөр "BHP", "Rio Tinto", "Glencore", "Anglo American" зэрэг дөрвөн компанийн чөлөөт мөнгөн урсгал өдрийн 87 сая ам.долларт хүрч, нэмэгдсэн болохыг "Bloomberg"-ийн шинжээчид тооцоолсон байна. Шинжээчдийн үзэж байгаагаар хэдэн жилийн өмнө компаниуд нэгдэн, нийлэх хэлцэлд бэлэн мөнгөний нөөцөө зарцуулах хандлага давамгайлжээ. Харин энэ жилийн хувьд өрийн дарамтаа бууруулж, хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тараахад төвлөрч байгаа юм байна. Тухайлбал, "Glencore" компани хувьцаа эзэмшигчдэдээ 2.9 тэрбум ам.долларын ногдол ашиг тарааж, өрийн хэмжээг 10.7 тэрбум ам.доллар болгож бууруулжээ.

Харин "Оюу Толгой"-ийн хөрөнгө оруулагч "Rio Tinto" компанийн 2017 оны ногдол ашиг 71 хувиар нэмэгдэж, 5.2 тэрбум ам.долларт хүрсэн байна. Үүнээс гадна нэг тэрбум ам.долларын хувьцааг 2018 онд багтаан эргүүлэн худалдаж авахаар болжээ. Үр дүнд нь хувьцаа эзэмшигчдэдээ эргүүлэн олгож байгаа нийт бэлэн мөнгөний хэмжээ нь 9.7 тэрбум ам.долларт хүрч, харин өрийн хэмжээ нь 3.8 тэрбум ам.доллар болж буураад байгаа юм.

Эх сурвалж: BloombergTV.mn



2017 онд 21 уурхай шинээр үйл ажиллагаа эхлүүлжээ

2017 онд уул уурхайн салбарт олон уурхай шинээр нээгдсэн, салбарын түвшинд тодорхой өсөлт бий болсон дүр зураг харагдаж байна. Ялангуяа алтны салбарт дотоодын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд олборлолтоо эхлүүлсэн нь дэвшилттэй алхам байлаа.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны мэдээлснээр, өнгөрсөн жил шинээр 21 уурхай үйл ажиллагаа эхэлж, 1 баяжуулах үйлдвэр ашиглалтад оржээ. Үүнээс алтны шороон ордод 11, нүүрсний 1, үлдсэн 9 нь бусад төрлийн ашигт малтмалын уурхайнууд юм. Төв аймгийн Заамарын бүсэд гэхэд "Ар гоулд", "Мондулаан трэйд", "Нью Халпи", "Наран гоулд", "Илт гоулд", Баян суманд "Эрдэнийн цахирмаа тал", Булган аймгийн Бүрэгхангай суманд "Хүслэмж", Дашинчилэн суманд "Цагаан уулын магнит" ХХК, Дорнод аймгийн Баяндун суманд "Би Жи Эм Би", Сэлэнгэ аймгийн Ерөө суманд "Ганбаттулга", "Ди зэт энд ай" компаниуд тус тус уурхайгаа нээжээ.

Эдгээр уурхайн ТЭЗҮ батлагдсан тул хууль, журмын дагуу таван жил тутамдаа тодотгол хийж, уулын ажлын төлөвлөгөөгөө жил жилээр батлуулаад явах юм байна.

Шинээр уурхай ашиглалтад оруулж байгаа аж ахуйн нэгжүүд хэчнээн ажлын байр бий болгож, орон нутагтай хэрхэн хамтран ажиллаж байгаа нь дутахгүй чухал үзүүлэлт билээ. Эдгээр компани 20-100 гаруй хүнийг ажлын байраар ханган ажиллаж байгаагаас "Мондулаан трэйд"-ийн шинэ уурхай хамгийн олон ажилтантай. Заамар суманд үйл ажиллагаа явуулж байгаа алтны компаниудаас "Мондулаан трэйд", "Ар гоулд", "Нью Халпи" компани 2017 онд орон нутгийн засаг захиргаатай гэрээ байгуулан ажилчдынхаа 20-иос дээшгүй хувийг сумын иргэдээс хангах, сумын оёдлын цехээр ажлын хувцсаа оёулах, сүүн бүтээгдэхүүний хангалтаа сумаас хийх зэргээр хамтран ажилласан байна.

"Цагаан уулын магнит" ХХК-ийн хувьд Дашинчилэн сумын Доргонт багийн төвийг шинээр барих ажлыг санхүүжүүлж, бүрэн тохижуулж хүлээлгэн өгсөн нь 2017 онд хийж гүйцэтгэсэн томоохон ажлуудын нэг болжээ. Нийгмийн хариуцлагын хүрээнд 70 гаруй хүнийг ажлын байраар хангаснаас 20 гаруй нь орон нутгийн иргэд аж. "Эрдэнийн цахирмаа тал" компани 2017 онд өөрийн 100%-ийн хөрөнгө оруулалтаар Баян сумын Эрүүл мэндийн төвийн эрүүл мэндийн сургалтын өрөө, чийрэгжүүлэлтийн танхимыг бүрэн тохижуулж хүлээлгэн өгсөн нь мөн сум орон нутагт хийсэн дорвитой хөрөнгө оруулалт болсон байна.

Эх сурвалж: MongolianMiningJournal.com

Энэтхэгийн "PMC" компани газрын тос боловсруулах үйлдвэр барих хүсэлтээ илэрхийлэв

Энэтхэг улс давуу эрхтэйгээр өөрийн орны "PMC" компаниар газрын тосны үйлдвэрийг бариулах сонгох санал гаргажээ. Үйлдвэрийг Энэтхэг улсын Засгийн газрын нэг тэрбум ам.долларын санхүүжилтээр барихаар тохирсон тул давуу эрхтэйгээр өөрийн орны компанийг сонгох санал гаргасан тухай Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яамнаас мэдээллээ. Дорноговь аймгийн Алтанширээ суманд барих үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ-ийг Энэтхэгийн Төрийн өмчит "EIL" компани хийж байгаа юм. Нарийвчилсан тоо, баримтыг гуравдугаар сарын сүүлээр танилцуулах юм байна. Үйлдвэрийг энэ оны II улирлаас барьж эхлэх шийдвэрийг Засгийн газар гаргаад байгаа юм. Үүнтэй холбогдуулан Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт 150 га талбайг улсын тусгай хэрэгцээнд авахаар тогтоод байна. Энэ байршлыг сонгохдоо дэд бүтэцтэй ойрхон, түүхий эдээ Дорнодын XIX, XXI талбайгаас татах боломжтойг харгалзан үзжээ. Мөн төмөр замаар Улаанбаатар хот болон бусад бүс рүү тээвэрлэх боломжтой гэдгийг холбогдох албаныхан онцолж байсан юм.

Газрын тосны үйлдвэр байгуулсан тохиолдолд түүхий эдээ хэрхэн хангах вэ гэдэг чухал бөгөөд одоогоор Монголд газрын тосны хоёр талбайд хайгуул хийхээр зарлаад байна. Түүнчлэн хайгуулын 22 талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулжээ. Үүнээс дөрвөн гэрээг цуцлуулах саналыг Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яаманд гаргасан болохыг Ашигт малтмал, Газрын тосны газар өмнө нь мэдээлж байсан юм.

Эх сурвалж: BloombergTV.mn



CONTACT US

Tel: 7010-0261, 311914
E-mail: info@tdbcapital.mn
Website: www.tdbcapital.mn
Facebook: www.tdbcapital.mn/facebook
Twitter: www.tdbcapital.mn/twitter

Address:

Trade and Development Bank, 14210
Peace avenue 19, Sukhbaatar district
1st khoroo, Ulaanbaatar, Mongolia

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.